



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Шаамар сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2024/184-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.selenge@audit.gov.mn

Сүхбаатар сум
2024 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа

Утас: 70363040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Батмөнх

Утас: 70363036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn

Аудитыг гүйцэтгэсэн: Их наяд аудит ХХК

Захирал: Х.Ариунзул

Утас: 99077062 Цахим хаяг: ikhnayadaudit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. АУДИТЫН ДҮГНЭЛТ	2
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	4
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	10
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	10
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	12
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	12
4. АУДИТЫН ТАЙЛАН	14
4.1 Ерөнхий зүйл	14
4.2 Материаллаг байдал	15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	16
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	17
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	18

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БШУС	Боловсрол, шинжлэх ухааны сайд
БШУЯ	Боловсрол, шинжлэх ухааны яам
БЕГ	Боловсролын ерөнхий газар
БШУГ	Боловсрол, шинжлэх ухааны газар
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
МУЕА	Монгол улсын ерөнхий аудитор
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ШААМАР
СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
Б.ӨСӨХЖАРГАЛ ТАНАА

2024.02.23 № СЭА-2024/84/НА-СТА-ТМЗ
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Шаамар сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Шаамар сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Шаамар сумын ерөнхий боловсролын сургууль нь Боловсролын Ерөнхий газрын даргын 2023 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн А/324 дүгээр тушаалаар сургалтын байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнгээр 4 дүгээр түвшинд үнэлэгдсэн байна.

Аудитын гол асуудал

Тус сургуулийн мөрдөж байгаа Боловсрол, Шинжлэх Ухааны сайдын 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/22 дугаар тушаалаар баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа боловсролын байгууллагын онцлогт тохирохгүй байна.

Байгууллагын төсөв, санхүүжилтийг зардлын эдийн засгийн ангиллаар нь бус “бараа үйлчилгээний бусад зардал” гэсэн ангиллаар бөөнд нь тусган, төлөвлөж, баталж байгаа нь төсвийг зардлын бүлэг, зүйлээр төлөвлөж, зарцуулах, зарцуулалтад хяналт тавих зарчмыг алдагдуулж байна.

Бусад асуудлын хэсэг

Тус байгууллага нь тайлант оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 8 зорилтын хүрээнд 19 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 91.5 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн байна.

Сэлэнгэ аймгийн засаг даргын 2023 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн захирамжаар Шаамар сумын ерөнхий боловсролын сургуулийн сургалт эрхлэх тусгай зөвшөөрөлд “дүйцсэн хөтөлбөрийн сургалт” явуулах эрхийг нэмж, нэмэлт өөрчлөлт оруулжээ.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	261,436,640.51	296,057,883.60
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	139,854,247.88	155,709,921.94
312	Банканд байгаа бэлэн мөнгө	139,854,247.88	155,709,921.94
3121	Төгрөг	139,854,247.88	155,709,921.94
31211	Төрийн сангийн харилцах	139,854,247.88	155,709,921.94
35	БАРАА МАТЕРИАЛ	121,582,392.63	140,347,961.66
351	Түүхий эд материал	14,164,390.26	16,879,569.29
35110	Тусгай зориулалттай материал	14,134,390.26	16,849,569.29
35130	Эм боох материал	30,000.00	30,000.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	37,000.00	1,941,700.00
354	Хангамжийн материал	107,381,002.37	121,526,692.37
35410	Бичиг хэргийн материал	33,300.00	-
35420	Аж ахуйн материал	49,010,447.65	57,615,487.65
35430	Сэлбэг хэрэгсэл	4,592,900.00	6,721,100.00
35450	Барилгын засварын материал	6,853,000.00	9,859,600.00
35460	Хүнсний материал	773,150.00	1,598,300.00
35470	Бусад хангамжийн материал	46,118,204.72	45,732,204.72
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,132,634,575.06	2,061,898,100.96
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,132,634,575.06	2,061,898,100.96
392	Биет хөрөнгө	2,099,336,607.94	2,029,416,954.69
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,030,135,596.00	2,030,135,596.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(203,823,308.00)	(242,431,288.94)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	14,562,500.00	14,562,500.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(7,888,020.79)	(13,348,958.26)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	272,333,306.01	266,853,027.41
39206	Хуримтлагдсан элэгдэл	(137,923,820.51)	(134,704,348.03)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	127,978,765.02	138,497,724.97
39208	Хуримтлагдсан элэгдэл	(68,174,693.77)	(82,669,768.70)
39214	Бусад үндсэн хөрөнгө	65,007,018.00	65,007,018.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(17,926,842.99)	(26,848,732.35)
39217	Ном	25,056,108.97	14,364,184.59
393	Биет бус хөрөнгө	33,297,967.12	32,481,146.27
39301	Программ хангамж	6,001,027.55	6,001,027.55
39302	Хуримтлагдсан элэгдэл	(2,967,060.43)	(3,783,881.28)
39303	Бусад биет бус хөрөнгө	30,264,000.00	30,264,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,394,071,215.57	2,357,955,984.56
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,394,071,215.57	2,357,955,984.56
51	Засгийн газрын хувь оролцоо	2,394,071,215.57	2,357,955,984.56
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	756,321,843.72	756,321,843.72
512	Хуримтлагдсан үр дүн	28,045,327.39	(8,069,903.62)
51210	Өмнөх үеийн үр дүн	(2,228,063,257.63)	(2,228,063,257.63)
51220	Тайлант үеийн үр дүн	2,256,108,585.02	2,219,993,354.01
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,609,704,044.46	1,609,704,044.46
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,394,071,215.57	2,357,955,984.56

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,440,102,790.02	1,156,662,623.20
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,421,411,448.76	49,733,823.20
120	Нийтлэг татварын бус орлого	2,421,411,448.76	49,733,823.20
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,502,900.00	7,915,428.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,502,900.00	4,415,428.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	3,500,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-ҮХ	2,282,603,836.65	26,195,832.50
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-БМ	136,304,712.11	15,622,562.70
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,018,691,341.26	1,106,928,800.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	867,701,300.00	929,943,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	867,701,300.00	929,943,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	150,990,041.26	176,985,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	150,990,041.26	176,985,800.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,183,994,205.00	1,179,149,898.73
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,183,994,205.00	1,179,149,898.73
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,147,179,705.00	1,131,764,998.73
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	710,893,968.50	684,596,732.38
210101	Үндсэн цалин	432,039,118.91	506,325,295.35
210102	Нэмэгдэл	258,806,219.59	155,022,471.23
210104	Урамшуулал	20,048,630.00	23,248,965.80
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	72,869,803.48	85,828,311.56
210201	Тэтгэврийн даатгал	53,052,740.32	58,825,455.10
210202	Тэтгэмжийн даатгал	5,110,023.59	7,102,617.79
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,087,725.90	5,531,532.06
210204	Ажилгүйдлийн даатгал	956,874.18	1,285,550.18
210205	Эрүүл мэндийн даатгал	9,662,439.49	13,083,156.43
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	106,190,126.79	171,093,200.00
210301	Гэрэл, цахилгаан	8,123,910.00	11,432,325.25
210302	Түлш, халаалт	95,066,216.79	156,885,674.75
210303	Цэвэр, бохир ус	3,000,000.00	2,775,200.00
2105	Нормативт зардал	27,138,570.00	34,934,200.00
210502	Хоол, хүнс	27,138,570.00	34,934,200.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,444,950.00	5,892,600.00
210604	Урсгал засвар	5,444,950.00	5,892,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,236,500.00	8,467,660.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	2,627,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	6,236,500.00	5,840,160.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	218,405,786.23	140,952,294.79
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	48,013,600.00	31,440,943.67
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,384,500.00	-

210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	161,007,686.23	109,511,351.12
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	36,814,500.00	47,384,900.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	36,814,500.00	47,384,900.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	36,814,500.00	37,859,900.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	9,525,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	2,256,108,585.02	(22,487,275.53)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	13,627,955.48
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	13,627,955.48
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	(13,627,955.48)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	2,256,108,585.02	(36,115,231.01)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,021,194,241.26	1,114,844,228.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,502,900.00	7,915,428.00
120	Нийтлэг татварын бус орлого	2,502,900.00	7,915,428.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,502,900.00	7,915,428.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,502,900.00	4,415,428.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	3,500,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,018,691,341.26	1,106,928,800.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	867,701,300.00	929,943,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	867,701,300.00	929,943,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	150,990,041.26	176,985,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	150,990,041.26	176,985,800.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	851,325,993.38	1,072,781,553.94
21	УРСГАЛ ЗАРДАЛ	851,325,993.38	1,072,781,553.94
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	814,511,493.38	1,025,287,653.94
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	569,247,443.11	673,059,143.94
210101	Үндсэн цалин	432,039,118.91	464,203,732.98
210102	Нэмэгдэл	117,159,694.20	185,547,524.81
210104	Урамшуулал	20,048,630.00	23,307,886.15
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	72,869,803.48	97,039,900.00
210201	Тэтгэврийн даатгал	53,052,740.32	65,980,500.00
210202	Тэтгэмжийн даатгал	5,110,023.59	7,762,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,087,725.90	6,209,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	956,874.18	1,552,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	9,662,439.49	15,525,300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	106,190,126.79	171,093,200.00
210301	Гэрэл, цахилгаан	8,123,910.00	11,432,325.25
210302	Түлш, халаалт	95,066,216.79	156,885,674.75

210303	Цэвэр, бохир ус	3,000,000.00	2,775,200.00
2104	□□□□□□□□, □□□□□□ □□□□□□□□□□□□ □□□□□□	-	74,100.00
210402	Тээвэр шатахуун	-	74,100.00
2105	Нормативт зардал	27,138,750.00	35,953,650.00
210502	Хоол, хүнс	27,138,750.00	35,953,650.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,444,950.00	5,892,600.00
210604	Урсгал засвар	5,444,950.00	5,892,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,236,500.00	8,717,660.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	2,627,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	6,236,500.00	6,090,160.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	27,384,100.00	33,463,400.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	17,999,600.00	24,192,070.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,384,500.00	9,271,330.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	36,814,500.00	47,493,900.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	36,814,500.00	47,493,900.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	36,814,500.00	39,570,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	7,923,600.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	169,868,247.88	42,062,674.06
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	30,014,000.00	26,207,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	30,014,000.00	26,207,000.00
223001	Бусад хөрөнгө	30,014,000.00	26,207,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(30,014,000.00)	(26,207,000.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	139,854,247.88	15,855,674.06
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	139,854,247.88
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	139,854,247.88	155,709,921.94

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	/төгрөгөөр/
				Засгийн газрын хувь оролцооны үр дүн
А	1	2	3	4
2021 оны 12 дугаар сарын 31-нээрх үлдэгдэл	756,321,843.72	1,609,704,044.46	(178,935,311.94)	2,187,090,576.24
НББ-ийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	756,321,843.72	1,609,704,044.46	(178,935,311.94)	2,187,090,576.24
ҮХ-ийн өсөлт, бууралт	-	-	-	-

ҮХ-ийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	206,980,639.33	206,980,639.33
2022 оны 12 дугаар сарын 31-нээрх үлдэгдэл	756,321,843.72	1,609,704,044.46	28,045,327.39	2,394,071,215.57
НББ-ийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
ҮХ-ийн өсөлт, бууралт	-	-	-	-
ҮХ-ийн дахин үнэлгээний бууралт	756,321,843.72	1,609,704,044.46	28,045,327.39	2,394,071,215.57
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	(36,115,231.01)	(36,115,231.01)
2023 оны 12 дугаар сарын 31-нээрх үлдэгдэл	756,321,843.72	1,609,704,044.46	(8,069,903.62)	2,357,954,984.56

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,253,154,600.00	1,098,988,553.94	154,166,046.06	87.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,253,154,600.00	1,098,988,553.94	154,166,046.06	87.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,195,670,500.00	1,051,494,653.94	144,175,846.06	87.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	799,779,300.00	672,879,143.94	126,900,156.06	84.1
210101	Үндсэн цалин	551,281,300.00	464,023,732.98	87,257,567.02	84.2
210102	Нэмэгдэл	219,199,400.00	185,547,524.81	33,651,875.19	84.6
210104	Урамшуулал	29,298,600.00	23,307,886.15	5,990,713.85	79.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	99,972,300.00	97,030,900.00	2,941,400.00	97.1
210201	Тэтгэврийн даатгал	67,981,100.00	65,980,500.00	2,000,600.00	97.1
210202	Тэтгэмжийн даатгал	7,997,800.00	7,762,500.00	235,300.00	97.1
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,398,200.00	6,209,800.00	188,400.00	97.1
210204	Ажилгүйдлийн даатгал	1,599,600.00	1,552,800.00	46,800.00	97.1
210205	Эрүүл мэндийн даатгал	15,995,600.00	15,525,300.00	470,300.00	97.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	171,093,200.00	171,093,200.00	-	100.0

210301	Гэрэл, цахилгаан	10,747,100.00	11,432,325.25	(685,225.25)	106.4
210302	Түлш, халаалт	157,318,600.00	156,885,674.75	432,925.25	99.7
210303	Цэвэр, бохир ус	3,027,500.00	2,775,200.00	252,300.00	91.7
2105	Нормативт зардал	44,989,900.00	35,953,650.00	9,036,250.00	79.9
210502	Хоол, хүнс	44,989,900.00	35,953,650.00	9,036,250.00	79.9
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,892,600.00	5,892,600.00	-	100.0
210604	Урсгал засвар	5,892,600.00	5,892,600.00	-	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,321,500.00	8,717,660.00	3,603,840.00	70.8
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,226,400.00	2,627,500.00	3,598,900.00	42.2
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	6,095,100.00	6,090,160.00	4,940.00	99.9
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	61,621,700.00	59,927,500.00	1,694,200.00	97.3
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	52,328,300.00	50,653,170.00	1,675,130.00	96.8
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,293,400.00	9,274,330.00	19,070.00	99.8
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	57,484,100.00	47,493,900.00	9,990,200.00	82.6
2132	Бусад урсгал шилжүүлэг	57,484,100.00	47,493,900.00	9,990,200.00	82.6
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	49,560,500.00	39,570,300.00	9,990,200.00	79.84
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,923,600.00	7,923,600.00	-	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,253,154,600.00	1,114,844,228.00	138,310,372.00	89.0
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	929,943,000.00	929,943,000.00	-	100.0
131001	Улсын төсвөөс санхүүжих	929,943,000.00	929,943,000.00	-	100.0
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	176,985,800.00	176,985,800.00	-	100.0
132001	Орон нутгийн төсвөөс	176,985,800.00	176,985,800.00	-	100.0
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	6,371,500.00	7,915,428.00	(1,543,928.00)	124.2
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,583,500.00	4,415,428.00	168,072.00	96.3

1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,788,000.00	3,500,000.00	(1,712,000.00)	195.7
	Урьд оны үлдэгдлээс	139,854,300.00			
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	139,854,247.88		-
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	155,709,921.94		-
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	-	-		-
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1		100.0
610001	Төсвийн байгууллага	1	1		100.0
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	44	44		100.0
620001	Удирдах ажилтан	4	4		100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	26	26		100.0
620003	Үйлчлэх ажилтан	14	14		100.0
010	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	395	395		100.0
011	Ерөнхий боловсролын сургуульд суралцагчид	395	395		100.0
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ				

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сэлэнгэ аймгийн Шаамар сумын ерөнхий боловсролын сургууль нь "Сургалтын байгууллагын менежментийг сайжруулах" 2023-2024 оны хичээлийн жилийг "Суралцагчийн сурахад тулгарч буй бэрхшээлийг арилгах, сэтгэл зүйн таатай орчинд суралцах боломжийг бүрдүүлэх, хүүхдийн болон багшийн бүх талын тасралтгүй хөгжлийг хангахад оршино" гэсэн эрхэм зорилгын хүрээнд 10 зорилтыг хэрэгжүүлэн ажилласан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Боловсролын ерөнхий хууль 2023 оны 07 дугаар сарын 07-нд батлагдсан,
- Хөдөлмөрийн тухай хуульд 2023 оны 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,

- Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2023 оны 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 241 дүгээр тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон,
- БШУС-ын 2023 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн 1/2714 тоот албан бичгээр боловсролын байгууллагын төсвийн шинэчлэлийн хүрээнд “ЕБС-д сургалтын тоног төхөөрөмжийн нөхөн хангалт шийдвэрлэх”; гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналт, үйл ажиллагааны зохион байгуулалтын хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Тайлант онд тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд БШУЯ-ны Хяналт, шинжилгээ үнэлгээний газрын Дотоод аудитын хэлтсээс хяналт, шалгалт хийгдээгүй боловч сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан дотоод хяналт, шалгалтыг хэрэгжүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Шаамар сумын ерөнхий боловсролын сургууль нь 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь Боловсрол, Шинжлэх Ухааны сайдын 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/22 дугаар тушаалаар баталсан Боловсрол, Шинжлэх Ухааны салбарын төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа төсөвт байгууллагуудад мөрдөгдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд суурилсан төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн талаар нарийн тусгаагүй өөрөөр хэлбэл боловсролын салбарын онцлогт тохироогүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Сэлэнгэ аймгийн Шаамар сумын ерөнхий боловсролын сургууль нь 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө 2,357,956.0 мянган төгрөг болж өмнөх оноос 36,115.2 мянган төгрөгөөр буюу 1.5 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	139,854.2	155,709.9	15,855.7
Авлага			
Бараа материал	121,582.4	140,348.0	18,765.6
Үндсэн хөрөнгө	2,132,634.6	2,061,898.1	(70,736.5)
Нийт хөрөнгө	2,394,071.2	2,357,956.0	(36,115.2)
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	2,394,071.2	2,357,956.0	(36,115.2)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	2,394,071.2	2,357,956.0	(36,115.2)

Дээрх хүснэгтээс харахад дараах дансанд нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгийн данс 155,709.9 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь Төсвийн тухай хуулийн 7.9-д заасны дагуу тайлант жилийн үйл ажиллагааны зардлын хэмнэлтийг төрийн сангийн харилцах дансанд үлдэгдлээр тайлагнасантай холбоотой байна.
- Бараа материалын дансны үлдэгдэл 140,348.0 мянган төгрөг болж 18,765.6 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 104,349.7 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 15,622.6 мянган төгрөгийн бараа материал үнэ төлбөргүй хүлээн авч, 101,206.7 мянган төгрөгийн бараа материал зарцуулснаас шалтгаалсан байна.
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,061,898.1 мянган төгрөг болж 70,736.5 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд байгуулсан элэгдлийн зардалтай холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь

тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,111,781.2 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 176,985.8 мянган төгрөг нийт **1,288,767.0** мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснээс өөрчлөлтгүй баталсан.

Төсвийн жилийн дундуур улсын төсвийн санхүүжилтийг **35,612.4** мянган төгрөг болгон бууруулж улсын төсвийг 929,943.0 мянган төгрөгөөр, үйл ажиллагааны орлогыг 6,371.5 мянган төгрөг, урьд оны санхүүжилтээс 139,854.3 мянган төгрөг, орон нутгийн төсвийн санхүүжилтийг 176,985.8 мянган төгрөгөөр, нийт **1,253,154.6** мянган төгрөгөөр эцэслэн баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 14 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 929,943.0 мянган төгрөг, үйл ажиллагааны орлогыг 6,371.5 мянган төгрөг, урьд оны санхүүжилтээс 139,854.3 мянган төгрөг, орон нутгийн төсвийн санхүүжилтийг 176,985.8 мянган төгрөгөөр, нийт **1,253,154.6** мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд **1,098,988.5** мянган төгрөгийг зарцуулсан байна

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл **1,098,988.6** мянган төгрөг буюу **87.7** хувьтай байгаа байгаа нь цалин хөлс, нэмэгдэл урамшлын зардлыг 126,900.2 мянган төгрөгөөр, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 2,941.4 мянган төгрөгөөр, норматив зардлыг 9,036.3 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр 3,603.8 мянган төгрөг, бараа, үйлчилгээний бусад зардал 1,694.1 мянган төгрөгөөр, урсгал шилжүүлэг зардлыг 9,990.2 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

							/мянган төгрөгөөр/	
Д/Д	Хөтөлбөр	д/д	Арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт	
1	71802 Ерөнхий боловсрол	1	Байр ашиглалтын үйлчилгээ	2,438.0	2,438.0	-	100.0	
		2	Бичиг үсгийн боловсролын хөтөлбөр	2,415.0	483.0	1,932.0	20.0	
		3	Боловсролын байгууллагын багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх	5,485.6	5,479.7	5.9	99.9	
		4	Боловсролын стандарт, сургалт	734,202.0	624,063.6	110,138.4	85.0	
		5	Гүнзгийрүүлсэн болон төрөлжсөн	860.0	-	860.0	-	

6	Дотуур байрны үйлчилгээ	72,188.9	53,746.8	18,442.1	74.5
7	Сурах бичгийн түрээс	6,226.4	2,627.5	3,598.9	42.2
8	Сургалт семинар	1,219.0	1,218.8	0.2	100.0
9	Сургалтын хэвийн үйл ажиллагаа	171,754.2	163,365.0	8,389.2	95.1
11	Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	176,985.8	176,985.8	-	100.0
12	үдийн цай хөтөлбөр	49,560.5	39,570.3	9,990.2	79.8
13	Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	27,381.2	27,381.1	0.1	100.0
Нийт		1,253,154.6	1,098,988.6	154,166.0	87.7

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Сэлэнгэ аймгийн Шаамар сумын ерөнхий боловсролын сургууль нь 2023 онд улсын төсвийн хөрөнгөөр хүүхдийн хоол хүнс худалдан авах 44,989.9 мянган төгрөг төсөв батлагдсан байна.

Тайлант онд худалдан авах ажиллагааны урилгыг tender.gov.mn цахим сайтад байршуулж, худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулсан байна. Бэлтгэн нийлүүлэгчийг сонгон шалгаруулах худалдан авах ажиллагааны шалгаруулалтад "Номун сэлэнгэ" ХХК, "Өсөх эрдэнэт сүрэг" ХХК оролцож, гүйцэтгэгчээр шалгаран гэрээ байгуулан, худалдан авалтыг гүйцэтгэсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Шаамар сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу "Их наяд аудит" ХХК-ийн аудитор Х.Ариунтуяа гүйцэтгэж, хяналтыг захирал Х.Ариунзул, дараагийн шатны хяналтыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сэлэнгэ аймгийн Шаамар сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Их наяд аудит” ХХК-д 2024 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 05 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн шатны материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,183,994.2 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 11,839.9 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Шаамар сумын ерөнхий боловсролын сургууль нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Үйл ажиллагаатай холбоотой сурталчилгаа, баяр ёслолын арга хэмжээг зохион байгуулаагүй, төсвийн хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдаж аваагүй,
- Шаардлагагүй бараа материалыг их хэмжээгээр авч нөөцлөөгүй,
- Хэвлэл захиалгын төлбөр гаргалгүй ажилласан зэрэг төсвийн шууд захирагчтай хамааралтай заалтуудыг мөрдөж, батлагдсан төсвийн хүрээнд ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны нэгдсэн системд нийт мэдээлбэл зохих 28 төрлийн 159 мэдээлэл байршуулахаас тус байгууллага нь мэдээллийг цаг хугацаанд нь ил тод, бүрэн байршуулж мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

1. Бусад хууль тогтоомжтой холбоотой асуудал

Тайлант онд бусад хууль, тогтоомжийн хэрэгжилтэд хамаарах алдаа, зөрчил илрээгүй.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2023 оны 10 дугаар сарын 26-ны 123 дугаар “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд 2023 оны санхүүгийн тайлангийн завсрын аудитаар 23,981.7 мянган төгрөгийн 2 алдаа, зөрчил илэрснийг залруулсан.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 2,195.6 мянган төгрөгийн зөрчил илэрснээс цахим төлбөрийн баримтгүйгээр ажил гүйлгээг гүйцэтгэсэн, авлага үүсгэсэн, шилэн дансны цахим хуудсанд 6 мэдээллийг хугацаа хоцроосон зэрэг зөрчилд 3 албан шаардлага, санхүүгийн тайлангийн тайлбар тодруулга хийх зөрчилд 1 зөвлөмж өгөгдсөн байна.

Аудитаар өгөгдсөн албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг нотлох баримттай тулган баталгаажуулахад 100 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
	Албан шаардлага	3	2,195.6	3	2,195.6
Зөвлөмж	1		1		100.0
Нийт дүн	4	2,195.6	4	2,195.2	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараах асуудлыг дээд шатны төсвийн захирагчийн санхүүгийн тайланд хийх аудитын анхааралд хандуулж байна. Үүнд:

1. Дээд шатны төсөв захирагчаас төсвийг зардлын эдийн засгийн ангиллаар нь бус “бараа үйлчилгээний бусад зардал” гэсэн ангиллаар бөөнд нь тусган, төлөвлөж, баталж байгаа нь төсвийг зардлын бүлэг, зүйлээр төлөвлөж, зарцуулах, зарцуулалтад хяналт тавих зарчмыг алдагдуулж байна.

Иймд төсвийг бодит гүйцэтгэлтэй нь уялдуулан зардлын бүлэг, зүйл бүрээр төлөвлөж, зарцуулан гүйцэтгэж байх шаардлагатай байна.

2. Цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан үндсэн хөрөнгийн тооллого хийж, биет тест хэрэгжүүлэх горимыг бүрэн хэрэгжүүлээгүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 23,981.7 мянган төгрөгийн 2 алдаа илэрснийг аудитын явцад залруулав. Үүнд:

1. Иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудаас худалдан авалт хийхдээ 21,489.0 мянган төгрөгийн цахим баримтыг дутуу бүрдүүлсэн.
2. Цалингийн зардлыг журналд тусгахдаа 2,492.7 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна.

Аудитаар нийт 387.4 мянган төгрөгийн 2 зөрчил¹ илрүүлж, 2 зөвлөмж өглөө.

5.1 Зөвлөмж

1. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт: Үндсэн хөрөнгийн элэгдлийг үлдэх өртгөөс нь илүү байгуулж хасах 387.4 мянган төгрөгөөр тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.Аж ахуйн нэгж, байгууллага дараах бүртгэлийн стандартыг дагаж мөрдөнө: 4.1.1.Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт; мөн НББОУС-16[6] “Элэгдүүлэх дүн гэдэг нь хөрөнгийн өртөг болон түүнтэй адилтгах дүнгээс үлдэх өртгийг хассан дүн, Үндсэн хөрөнгө дансны үнэ нь үлдэгдэл өртгөөс давж болохгүй.” гэсэн заалттай нийцэхгүй байна..

1.2 Өгсөн зөвлөмж: Үндсэн хөрөнгийн элэгдлийг үнэн зөв тооцоолж, бүртгэл тайланд тусгах.

2. Цалингийн данстай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт: Шаамар сумын Эрүүл мэндийн төвд үндсэн орон тоонд нягтлан бодогчоор ажиллаж буй Ц.Одонтуяаг тус сургуульд зэрэгцсэн хөдөлмөрийн гэрээгээр нягтлан бодогчоор ажиллуулан, цалинжуулж / үндсэн цалингийн 100.0 хувиар тооцож / байгаа нь дараах хуулиудыг тус тус зөрчиж байна. Үүнд:

- Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1 дэх “ Төрийн албан хаагч дараах нийтлэг үүрэг хүлээнэ” 37.1.17: “Үндсэн ажлаасаа гадуур хуулиар зөвшөөрснөөс бусад ажил, үүрэг эрхлэхгүй байх”,
- 38 дугаар зүйлийн 38.1 дэх “Төрийн албан хаагч дараах нийтлэг эрх эдэлнэ”, 38.1.6: “Багшлах, эрдэм шинжилгээний ажил эрхлэх”, 38.1.7“Хууль тогтоомжоор хориглоогүй, албан тушаалын ашиг сонирхолд харшлахгүй арга хэлбэрээр хувийн аж ахуй эрхлэх....”,

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

- Хөдөлмөрийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.3 дахь “Зэрэгцсэн хөдөлмөрийн гэрээтэй ажилтны нийт ажлын цаг энэ хуулийн 84.4 -т заасан ажлын цагийн дээд хязгаарт багтах ёстой бөгөөд үүнд ажилтан, үндсэн болон зэрэгцсэн ажил олгогч тус тус хяналт тавина”, 84 дүгээр зүйлийн 84.4 дэх “ Долоо хоногийн ажлын цагийн дээд хязгаар нь 56 цагаас илүүгүй байна. Өдөрт ажиллах илүү цагийн хязгаар нь дөрвөн цагаас илүүгүй байна” зэрэг.

2.2 Өгсөн зөвлөмж: 2 байгууллагад зэрэгцээ хөдөлмөрөөр нягтлан бодогчийн албан тушаал эрхлүүлж буй зөрчлийг таслан зогсоож, зайлшгүй тохиолдолд цалинг өдрийн 4 цагаар бодож, 50.0 хувиас хэтрүүлэхгүй байх.

Дээрх зөвлөмжүүдийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5² дахь заалтад тусгасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2024 оны 06 дугаар сарын 15 -ны өдрийн дотор тус тус төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

² Шалгадагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Цахим баримтгүй худалдан авалт гүйцэтгэсэн	1	21,489.0			1	21,489.0	1	21,489.0				
Цалингийн зардлыг журналд мөнгөн сууриар хөтөлж, бүртгэсэн	1	2,492.7			1	2,492.7	1	2,492.7				
Дүн	2	23,981.7			2	23,981.7	2	23,981.7				

/мянган төгрөгөөр/

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Үндсэн хөрөнгийн элэгдлийг илүү тооцож тайлагнасан.	1	387.4					1	387.4				
Нягтлан бодогчийг зэрэгцээ хөдөлмөрийн гэрээгээр ажилдуулсан.	1						1					
Дүн	2	387.4					2	387.4				

/мянган төгрөгөөр/

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс						/мянган төгрөгөөр/
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
Дүн									
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил									
Дүн									
Нийт дүн									